БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Баяннуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2025/183/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өлгий хот<br>2024 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл<br>Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn<br>Аудитын менежер: Х.Женисбек<br>Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Х.Еркебулан<br>Утас: 99427667 Цахим хаяг: erkebulankh@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**


**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ... 3
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ... 5
**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ... 11
**4. АУДИТЫН ТАЙЛАН** ... 15
**4.1 Ерөнхий зүйл** ... 15
**4.2 Материаллаг байдал** ... 15
**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** ... 16
**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** ... 16
**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ... 16
**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** ... 16
**4.5.1 Завсрын аудитын талаар** ... 16
**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал** ... 17
**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ... 17
**5.1 Төлбөрийн акт** ... 17
**5.2 Албан шаардлага** ... 17
**5.3 Зөвлөмж** ... 17
**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ... 18



**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ... 3
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ... 5
**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ... 11
**4. АУДИТЫН ТАЙЛАН** ... 15
**4.1 Ерөнхий зүйл** ... 15
**4.2 Материаллаг байдал** ... 15
**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** ... 16
**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** ... 16
**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ... 16
**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** ... 16
**4.5.1 Завсрын аудитын талаар** ... 16
**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал** ... 17
**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ... 17
**5.1 Төлбөрийн акт** ... 17
**5.2 Албан шаардлага** ... 17
**5.3 Зөвлөмж** ... 17
**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ... 18

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын стандарт |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

2025.02.28 № 232

танай __________ -ны № __________ -т

БАЯННУУР СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Х.ТОЙЛЫБАЙ
ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баяннуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Баяннуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд онцлох асуудал гараагүй байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.



83250200250

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.АЙГҮЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**Төгрөгөөр**

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **440,795,582.11** | **531,953,947.11** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 358,021,520.00 | 366,599,178.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 358,021,520.00 | 366,599,178.00 |
| **3121** | **Төгрөг** | 358,021,520.00 | 366,599,178.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 358,021,520.00 | 366,599,178.00 |
| **33** | **АВЛАГА** | - | 123,720.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 123,720.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 82,774,062.11 | 165,231,049.11 |
| **351** | **Түүхий эд материал** | 2,305,335.00 | 2,305,335.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 2,305,335.00 | 2,305,335.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 3,071,341.00 | 11,809,800.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 77,397,386.11 | 151,115,914.11 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,222,880.00 | 1,222,880.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 66,805,692.11 | 143,903,475.11 |
| 35450 | Барилгын засварын материал | 1,615,000.00 | 1,615,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 7,753,814.00 | 4,374,559.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,955,761,660.40** | **3,560,979,609.10** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 2,955,761,660.40 | 3,560,979,609.10 |
| **392** | **Биет хөрөнгө** | 2,902,642,421.40 | 3,508,145,017.90 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,295,892,921.00 | 3,320,140,330.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (207,157,747.25) | (277,034,579.29) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 439,560.00 | 439,560.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (439,560.00) | (439,560.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 369,353,949.38 | 602,378,439.38 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (205,119,453.48) | (254,665,455.79) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 105,531,242.80 | 105,531,242.80 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (69,385,140.37) | (74,465,774.77) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 15,000,000.00 | 31,396,925.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | - | (818,320.52) |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 554,000,000.00 | - |
| 39217 | Ном | 44,526,649.32 | 55,682,211.09 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 53,119,239.00 | 52,834,591.20 |
| 39301 | Програм хангамж | 1,973,239.00 | 1,973,239.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (550,000.00) | (834,647.80) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 51,696,000.00 | 51,696,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,396,557,242.51** | **4,092,933,556.21** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,396,557,242.51** | **4,190,192,556.27** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 3,396,557,242.51 | 4,190,192,556.27 |

| | | | |
|---|---|---|---|
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 462,853,876.30 | 462,853,876.30 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,880,742,625.87 | 2,674,377,939.63 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,340,342,738.74 | 1,880,742,625.87 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 540,399,887.13 | 793,635,313.76 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,052,960,740.34 | 1,052,960,740.34 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,396,557,242.51** | **4,190,192,556.27** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

**Төгрөгөөр**

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **3,581,477,003.00** | **5,395,450,227.77** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **319,090,103.00** | **1,390,290,927.77** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 319,090,103.00 | 1,390,290,927.77 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 3,277,000.00 | 2,959,600.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,277,000.00 | 2,959,600.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 306,448,183.00 | 1,354,710,385.77 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | 9,364,920.00 | 32,620,942.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **3,262,386,900.00** | **4,005,159,300.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 2,777,954,900.00 | 3,673,159,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,777,954,900.00 | 2,777,954,900.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 484,432,000.00 | 332,000,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 484,432,000.00 | 332,000,000.00 |
| 2 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **3,000,243,261.75** | **4,047,814,914.01** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,000,243,261.75** | **4,047,814,914.01** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,904,654,200.75 | 3,920,529,639.01 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,967,301,976.00 | 2,977,479,620.00 |
| 210101 | Үндсэн цалин | 1,346,261,732.00 | 1,963,561,121.00 |
| 210102 | Нэмэгдэл | 529,038,064.00 | 892,784,209.00 |
| 210104 | Урамшуулал | 92,002,180.00 | 121,134,290.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 247,381,564.00 | 371,289,291.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 171,589,864.00 | 259,040,726.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 21,447,900.00 | 29,774,796.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 17,158,100.00 | 22,028,516.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,290,000.00 | 12,805,579.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 32,895,700.00 | 47,639,674.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 463,842,370.00 | 284,498,356.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,058,409.00 | 11,766,656.00 |
| 210302 | Түлш, халаалт | 454,783,961.00 | 272,731,700.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 5,519,750.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,519,750.00 | |
| **2105** | **Нормативт зардал** | 72,386,705.00 | 68,467,495.00 |
| 210502 | Хоол, хүнс | 72,386,705.00 | 68,467,495.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,708,691.00 | 4,997,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,708,691.00 | 4,997,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 12,723,000.00 | 15,305,316.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,277,000.00 | 2,959,100.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 9,446,000.00 | 12,346,216.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 130,790,144.75 | 198,492,061.01 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 48,273,738.00 | 53,302,684.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,190,850.00 | 19,582,940.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 75,325,556.75 | 125,606,437.01 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 95,589,061.00 | 127,285,275.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 78,099,431.00 | 84,781,131.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 78,099,431.00 | 84,781,131.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 17,489,630.00 | 42,504,144.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 17,489,630.00 | 42,504,144.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **581,233,741.25** | **1,347,635,313.76** |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | 4,399,638.00 | - |
| 145002 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз | 4,399,638.00 | - |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 45,233,492.12 | 554,000,000.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 45,233,492.12 | - |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | - | 554,000,000.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (40,833,854.12) | (554,000,000.00) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **540,399,887.13** | **793,635,313.76** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

**Төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **3,265,663,900.00** | **4,008,118,900.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **3,277,000.00** | **2,959,600.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 3,277,000.00 | 2,959,600.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 3,277,000.00 | 2,959,600.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,277,000.00 | 2,959,600.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **3,262,386,900.00** | **4,005,159,300.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 2,777,954,900.00 | 3,673,159,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,777,954,900.00 | 3,673,159,300.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 484,432,000.00 | 332,000,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 484,432,000.00 | 332,000,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **2,920,728,650.00** | **3,972,168,242.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,920,728,650.00** | **3,972,168,242.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,823,638,770.00** | **3,836,144,508.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,942,140,802.00 | 2,975,780,630.00 |
| 210101 | Үндсэн цалин | 1,321,100,558.00 | 1,962,468,600.00 |
| 210102 | Нэмэгдэл | 529,038,064.00 | 892,177,740.00 |
| 210104 | Урамшуулал | 92,002,180.00 | 121,134,290.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 268,098,100.00 | 373,112,001.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 182,306,400.00 | 253,853,593.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 21,447,900.00 | 29,865,069.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 17,158,100.00 | 14,968,548.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,290,000.00 | 14,885,358.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 42,895,700.00 | 59,539,433.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 463,842,370.00 | 284,498,356.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,058,409.00 | 11,766,656.00 |
| 210302 | Түлш, халаалт | 454,783,961.00 | 272,731,700.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 76,239,798.00 | 65,088,240.00 |
| 210502 | Хоол, хүнс | 76,239,798.00 | 65,088,240.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,100,000.00 | 4,997,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,100,000.00 | 4,997,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 12,723,000.00 | 23,404,716.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,277,000.00 | 2,959,100.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 9,446,000.00 | 20,445,616.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 57,494,700.00 | 109,263,065.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 39,315,400.00 | 87,758,865.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 18,179,300.00 | 21,504,200.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **97,089,880.00** | **136,023,734.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 79,600,250.00 | 93,519,590.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 79,600,250.00 | 93,519,590.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 17,489,630.00 | 42,504,144.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 17,489,630.00 | 42,504,144.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | 344,935,250.00 | 35,950,658.00 |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **63,399,000.00** | **27,373,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **63,399,000.00** | **27,373,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 63,399,000.00 | 27,373,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 63,399,000.00 | 27,373,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 6 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | (63,399,000.00) | (27,373,000.00) |
| 7 | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 281,536,250.00 | 8,577,658.00 |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 76,485,270.00 | 358,021,520.00 |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 358,021,520.00 | 366,599,178.00 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

**Төгрөгөөр**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | | | | 0.00 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | 0.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | 0.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | | 0.00 |
| C08 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 462,853,876.30 | 1,125,468,258.34 | 1,267,835,220.74 | 2,856,157,355.38 |
| D01 | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 462,853,876.30 | 1,125,468,258.34 | 1,267,835,220.74 | 2,856,157,355.38 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 72,507,518.00 | 72,507,518.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 462,853,876.30 | 1,052,960,740.34 | 1,880,742,625.87 | 3,396,557,242.51 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 793,635,313.76 | 793,635,313.76 |
| D09 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 462,853,876.30 | 1,052,960,740.34 | 2,674,377,939.63 | 4,190,192,556.27 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**Төгрөгөөр**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |

| | | | |
|---|---|---|---|
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 358,021,520.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 4,333,595,800.00 | 3,957,037,098.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 4,333,595,800.00 | 3,957,037,098.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 4,236,132,800.00 | 3,863,517,508.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 3,107,131,500.00 | 2,975,780,630.00 |
| 210101 | Үндсэн цалин | 2,074,333,100.00 | 1,962,468,600.00 |
| 210102 | Нэмэгдэл | 909,340,400.00 | 892,177,740.00 |
| 210104 | Урамшуулал | 123,458,000.00 | 121,134,290.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 388,391,300.00 | 373,112,001.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 264,106,100.00 | 253,853,593.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 31,071,300.00 | 29,865,069.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 15,535,700.00 | 14,968,548.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 15,535,700.00 | 14,885,358.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 62,142,500.00 | 59,539,433.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 318,440,000.00 | 284,498,356.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 14,272,000.00 | 11,766,656.00 |
| 210302 | Түлш, халаалт | 304,168,000.00 | 272,731,700.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 218,589,300.00 | 65,088,240.00 |
| 210502 | Хоол, хүнс | 218,589,300.00 | 65,088,240.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,000,000.00 | 4,997,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,000,000.00 | 4,997,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 54,812,600.00 | 36,311,716.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,959,100.00 | 2,959,100.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 51,853,500.00 | 33,352,616.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 143,768,100.00 | 123,729,065.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 122,231,300.00 | 102,192,265.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 21,536,800.00 | 21,536,800.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 97,463,000.00 | 93,519,590.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 97,463,000.00 | 93,519,590.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 97,463,000.00 | 93,519,590.00 |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 4,333,595,800.00 | 3,965,614,756.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 3,673,159,300.00 | 3,673,159,300.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 3,673,159,300.00 | 3,673,159,300.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 323,440,000.00 | 289,495,856.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 323,440,000.00 | 289,495,856.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 336,996,500.00 | 2,959,600.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,959,100.00 | 2,959,600.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 334,037,400.00 | |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 358,021,520.00 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 366,599,178.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 123.00 | 123.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 82.00 | 82.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 40.00 | 40.00 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 874.00 | 874.00 |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | 874.00 | 874.00 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 874.00 | 874.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **123.00** | **123.00** |
| 650004 | СӘБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 80.00 | 80.00 |
| 650006 | Соёл урлагийн салбарын тєрийн їйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | 1.00 | 1.00 |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 1.00 | 1.00 |
| 650009 | Тєрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 41.00 | 41.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Баяннуур сумын Ерөнхий боловсролын сургууль нь Баяннуур сумын Ерөнхий боловсролын сургууль нь хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжиж бага, дунд боловсрол олгох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Баяннуур сумын Ерөнхий боловсролын сургууль нь Баяннуур сумын Ерөнхий боловсролын сургууль нь сурах, хөгжих, тоглох, амрах , амьдрах бүх орчныг  бүрдүүлэх, байгууллагын санхүүгийн болон бусад үйл ажиллагаанд ил тод байдлыг хангаж ажиллах гэсэн зорилго дэвшүүлсэн ажиллажээ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Баяннуур сумын Ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Баяннуур сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2024 онд дотоод аудитын шалгалтад хамрагдаагүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баяннуур сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

**Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар**

Баяннуур сумын Ерөнхий боловсролын сургууль нь Захирлын 2023 оны 01 сарын 10-ны өдрийн Б/02 дугаар захирамжаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажилласан байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баяннуур сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны 229 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Байгууллагын хөтөлбөл зохих нягтлан бодох бүртгэлийг холбогдох заавар журмын дагуу хөтөлж, бараа материалын тайланг гаргаж, цалингийн цэсэд хавсаргах холбогдох тушаал, шийдвэр болон санхүүгийн анхан шатны баримтуудыг зохих журмаар бүрдүүлсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,190.2 сая төгрөгөөр буюу 793.6 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 358,021.52 | 366,599.18 | 8,577.7 |
| Авлага | 0.00 | 123.72 | 123.7 |

| | | | |
|---|---|---|---|
| Урьдчилгаа | 0.00 | 0.00 | 0.0 |
| Бараа материал | 82,774.06 | 165,231.05 | 82,457.0 |
| Үндсэн хөрөнгө | 2,955,761.66 | 3,560,979.61 | 605,217.9 |
| **Нийт хөрөнгө** | **3,396,557.24** | **4,092,933.56** | **696376.3** |
| Өр төлбөр | 0.00 | 0.00 | 0.0 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 3,396,557.24 | 4,190,192.56 | 793,635.3 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **3,396,557.24** | **4,190,192.56** | **793,635.3** |

Мөнгөн хөрөнгө 366.6 сая төгрөгийн эцсийн үлдэгдэлтэй байна. Урьдчилгаа дансанд өөрчлөлт гараагүй.

Дансны авлага жилийн эцэст 0.1 сая төгрөгийн НДШ-ийн авлагатай холбоотой байна.

Бараа материалын дансанд бага дүнтэй, үндсэн хөрөнгийн дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.
Бараа материалын данс оны эхэнд 82.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба төсвийн хөрөнгөөр нийт 248.8 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 32.6 сая төгрөгийн бараа материалыг үнэгүй хүлээн авч, 198.9 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулж, оны эцэст 165.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Бараа материалын дансанд бүртгэлтэй ашиглах боломжгүй болсон бараа материалыг байгууллагын Өмч хамгаалах зөвлөлөөр дүгнэлт гаргуулж, данс бүртгэлээс хасах арга хэмжээ авах шаардлагатай байна.

Үндсэн хөрөнгийн данс оны эхэнд  2,955.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба тайлант онд 27.4 сая төгрөгийн төсвийн хөрөнгөөр худалдан авч, 1,316.7 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, оны эцэст 3,560.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Өглөг дансны оны эцэст өглөггүй гарсан байна.

Тайлант оны үр дүнгээр Засгийн газрын хувь оролцоо данс 793.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр зарлагын нийт дүнг 3,827.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийн төслийг хянаж, төсвийн төслийн саналаас  цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг 440.2 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 65.8 сая төгрөгөөр нийтдээ 506.0 сая төгрөгөөр нэмж, нийт төсвийг 4333.6 сая төгрөгөөр баталсан байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 506.0 сая төгрөгөөр нэмэгдэж, 4,333.6 сая төгрөгөөр тодотгосон байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 14 хөтөлбөрийн 14 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,999.6 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжилт авахаар тусгасан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 3,999.6 сая төгрөгийн санхүүжилт олгож, 358,0 сая төгрөгийг эхний үлдэгдлээс зарцуулж, жилийн эцэст 42.5 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,999.6 сая төгрөг буюу 100.0 хувьтай байна. Үндсэн үйл ажиллагааны зардлаас 3,999.6 сая төгрөг зарцуулсан байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Байр ашиглалтын үйлчилгээ | 5,323.6 | 5,323.6 | 0.0 | 100.0% |
| 2 | Хүүхэд хамгаалал | 5,557.2 | 5,557.2 | 0.0 | 100.0% |
| 3 | Сургалт семинар | 3,793.1 | 3,793.1 | 0.0 | 100.0% |
| 4 | Эрүүл мэндийг дэмжих | 5,323.6 | 5,323.6 | 0.0 | 100.0% |
| 5 | Үдийн цай хөтөлбөр | 71,410.2 | 71,410.2 | 0.0 | 100.0% |
| 6 | Дотуур байрны үйлчилгээ | 594,524.9 | 594,524.9 | 0.0 | 100.0% |
| 7 | Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 40,742.9 | 40,742.9 | 0.0 | 100.0% |
| 8 | Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх | 15,970.8 | 15,970.8 | 0.0 | 100.0% |
| 9 | Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр | 15,288.3 | 15,288.3 | 0.0 | 100.0% |
| 10 | Боловсролын стандарт, сургалтын | 2,774,689.9 | 2,774,689.9 | 0.0 | 100.0% |
| 11 | Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 132,336.0 | 132,336.0 | 0.0 | 100.0% |
| 12 | Сурах бичгийн түрээс | 2,959.1 | 2,959.1 | 0.0 | 100.0% |
| 13 | Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх | 8,198.8 | 8,198.8 | 0.0 | 100.0% |
| 14 | Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 323,440.0 | 323,440.0 | 0.0 | 100.0% |
| | **Дүн** | **3,999,558.4** | **3,999,558.4** | 0.00 | 100.0% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Санхүү-нийцлийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлийн судалгааны дүн дараах байдалтай байна.Үүнд:

Баяннуур сумын Ерөнхий боловсролын сургууль нь цалингийн сангаас ахмадын санд мөнгө төвлөрүүлж, зарцуулаагүй байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу 24.0 сая төгрөгийн хөрөнгийг шууд гэрээгээр худалдан авалт хийсэн байна.

Төсвөөс 2024 онд бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн /210801/ төсвөөс 2.9 сая төгрөгийг, бараа үйлчилгээний бусад зардлын /210901/ төсвөөс 102.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

Баяннуур сумын Ерөнхий боловсролын сургуульд 2024 онд 123 орон тоо батлагдсанаас гүйцэтгэлээр удирдах ажилтан 1, гүйцэтгэх ажилтан 82, үйлчлэх ажилтан 40 нийтдээ 123 орон тоогоор батлагдсан орон тоо, төсөвт багтаан ажилласан байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Баяннуур сумын Ерөнхий боловсролын сургууль нь тайлант онд нэмэлт төсөв аваагүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Баяннуур сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2024 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баяннуур сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Еркебулан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Баяннуур сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 04 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3,000.2 сая төгрөгөөс буюу 45.0 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэх шатанд материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 4,047.8 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 60.7 сая төгрөгөөр шинэчлэн тогтоов.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор урсгал засварын зардал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг нийтдээ 42.5 сая төгрөгөөр хэмнэсэн байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад алдаа, зөрчил илрээгүй.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгасан.

Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын нийтдээ 3.410.7 сая төгрөгийн 22 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 448.2 сая төгрөгийн 23 мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 129.2 сая төгрөгийн 14 мөнгөн гүйлгээг бүрэн мэдээлсэн байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100 хувьтай байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар алдаа, зөрчил илрээгүй тул нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар эхний хагас жилийн баримтыг хүлээн авч түүвэр сорил хийсэн бөгөөд алдаа зөрчил илрээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар 0.8 сая төгрөгийг акт тогтоосныг бүрэн биелүүлж биелэлтийг нь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан эрсдэлтэй гэж сонгосон данисуудад горим сорил хэрэгжүүлж, төсвийн зарцуулалтыг түүвэрлэн шалгасан тул төсвийн зарцуулалтын гүйцэтгэлийн шалгалтаар дэлгэрэнгүй шалгах шаардлагатай.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй. Аудитаар нийт 19.5 сая төгрөгийн зөрчил илэрч 8.1 сая төгрөгийн төлбөрийн албан шаардлага өгөгдөж, нийтдээ 11.4 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

### 5.2 Албан шаардлага

Аудитаар дараах зөрчилд албан шаардлага өгөгдлөө. Үүнд:

Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн "Урамшуулал олгох тухай" Б/39 дүгээр тушаалаар Төсвийн захирагч болон нягтлан бодогч нарт, Баяннуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн "Урамшуулал олгох тухай" Б/60 дугаар тушаалаар нягтлан бодогч, нярав нарт 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчилгүй дүгнэлт авсан гэж 8,114,000 төгрөгийн урамшуулал олгож, төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын хэмжээг хэтрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 6.4.1-д "*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", 16 дугаар зүйлийн 16.5-д "*Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ*", 16.5.5-т "*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*", Засгийн газрын 2019 оны "Журам батлах тухай" 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

### 5.3 Зөвлөмж

Аудитаар нийт 11.4 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгөв.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Төрийн цахим худалдан авалтын хэрэгжилттэй холбоотой асуудал**

1.1.Илрүүлэлт: Баяннуур сумын Ерөнхий боловсролын сургууль нь "БИ ЭН Электроникс" ХХК-аас нийтдээ 11,367.000 төгрөгийн үндсэн хөрөнгийг төрийн цахим худалдан авалтын тухай хууль тогтоомжийг зөрчиж худалдан авсан зөрчилд албан шаардлага өгөв.

*Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.13-т "Ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс худалдан авах бараа, үйлчилгээг цахим дэлгүүрт байршуулснаас өөр этгээдээс худалдан авахыг хориглоно", Төрийн хэмнэлтийн*

*тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-т ”Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ”, 14.4-т ”Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.*

<u>*1.2 Өгсөн зөвлөмж*</u>:Зөрчил арилгуулах зөвлөмж өгөв.

***2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

<u>*2.1. Илрүүлэлт:*</u>

Сургууль нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй /дотуур байрны хоол хүнс 65.1 сая төгрөг, үдийн хоол 93.5 сая төгрөг г.м/ байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44.1-т Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.”, 46.1-т “Захиалагч худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан төсөл, арга хэмжээ бүрээр харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр тайлагнана.” гэсэн заалттай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>*2.2 Өгсөн зөвлөмж*</u>: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлж ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

*Дээрх зөвлөмжүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.*

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын хэмжээг хэтрүүлсэн | 1 | 8,114.0 | | | 1 | 8,114.0 | | | | | | |
| Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй | 1 | | | | | | **1** | | | | | |
| **Дүн** | **2** | **8,114.0** | | | **1** | **8,114.0** | **1** | | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Төрийн цахим худалдан авалтын журам зөрчсөн | 1 | 11,367.0 | | | | | 1 | 11,367.0 |
| Дүн | | | | | | | | |
| **Нийт дүн** | **1** | **11,367.0** | | | | | **1** | **11,367.0** |